



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/56

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн О.Батцэнгэл (ГЭ88040119)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 8 дугаар гудамж 840 тоотод байршилтай 6308002920 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 663 м² газрын газар эзэмших эрхийг Б.Ганцэцэг (ГЮ85020500)-д, Г.Батдаваа (ГЮ73061810)-гийн Булган сум 6 дугаар баг Залуус 13 дугаар гудамж 1318 тоотод байршилтай 6308007626 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 388 м² газрын газар эзэмших эрхийг Д.Баасансүрэн (РК89021716)-д тус тус шилжүүлсүгэй.

2. Б.Ганцэцэг, Д.Баасансүрэн нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны Б/59 дүгээр захирамжийн О.Батцэнгэл, 2015 оны Б/88 дугаар захирамжийн Г.Батдаваа нартай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

